



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 2/85

Хэрлэн сум

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.1.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн орлогч
дарга:

Эрүүл мэндийн газрын дарга

Салбар зөвлөлийн нарийн
бичгийн дарга:

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусlamж
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэлийн
албаны ахлах мэргэжилтэн

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Хөдөлмөр халамжийн газрын дарга

Гэр, бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын
дарга

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

Нэгдсэн эмнэлгийн дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Статистикийн хэлтсийн дарга

2.

Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын Хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эх барих эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эх, барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч

Г.Жаргалбат – Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагын “Бор-Өндөр 2” орон нутгийн хөтөлбөрийн менежер

2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах чиг үүргийг хавсралтаар баталсугай.

3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд салбар дундын оролцоог хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 02 дүгээр сарын 13.....-ны
дугаар захирамжийн хавсралт

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус
салбар зөвлөлийн ажиллах чиг үүрэг

1. Аймгийн түвшинд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөөний бодлогын хэрэгжилтийг хангах
2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг шаардлагатай тохиолдол бүрт зарлан хуралдуулах
3. Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тушаал, хурлын тэмдэглэл гарна. Хэлэлцэн асуудлаарх холбогдох шийдвэрийг харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
4. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төр болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
5. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах
6. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чиглэлээр бодлогын баримт бичиг, тушаал, заавар, зөвлөмж, журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах
7. Өөрийн нутаг дэвсгэр дээр эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж бусад төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөнүүдтэй уялдуулах
8. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үнэлгээ хийж үр дүнг тооцон хэлэлцэж ажиллах
9. “Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний /2021-2024 он/ төлөвлөгөө болон төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор хийгдэж буй төсөл, арга хэмжээнүүдэд хяналт тавьж дүн шинжилгээ хийх
10. Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний үйл ажиллагааны үр дүнгийн тайланг холбогдох албан тушаалтаар албажуулан тогтоосон хугацаанд Эрүүл мэндийн яам, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд тус тус хүргүүлэх